



**МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 11 сарын 17 өдөр

Дугаар А/622

Есөнбулаг

Гамшгийн сангаас хөрөнгө
зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3 дахь заалт, аймгийн Онцгой комиссын 2023 оны 22 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Цээл сумын Дэрстэй багийн нутаг "Хүн толгой" гэх газарт тарваган тахал гарсан тохиолдлын голомтод ажилласан ажлын хэсэгт холбогдох зардал, Онцгой байдлын газрын шуурхай бүлэг 08 дугаар сараас 11 дүгээр сард гамшгийн дуудлагаар гарч ажилласан шатахууны зардлыг хавсралтаар баталсугай.

2. Зардалд шаардагдах 21,652,408 (хорин нэгэн сая зургаан зуун тавин хоёр мянга дөрвөн зуун найм) төгрөгийг аймгийн Гамшгийн сангаас зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Г.Чинбат)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О. АМГАЛАНБААТАР

Аймгийн Засаг даргын 2014 оны
11 дугаар сарын 17 ны өдрийн 612 дугаар
захирамжийн хавсралт

ЗАРДЛЫН ТООЦОО

№	Зардлын нэр	Мөнгөн дүн
1.	Эрүүл мэндийн газрын 1 хүний томилолтын зардал	423,000
2.	Цагдаагийн газрын 6 хүний томилолт, шатахууны зардал	3,012,000
3.	Онцгой байдлын газрын 4 хүний томилолт, шатахууны зардал	3,732,800
4.	Зоонозын өвчин судлалын төв 10 хүний томилолт, шатахууны зардал	5,664,000
5.	Цээл сумын Засаг даргын Тамгын газрын 3 хүний томилолт, шатахууны зардал	5,240,000
6.	Цээл сумын Эрүүл мэндийн төвийн 4 хүний томилолт, шатахууны зардал	1,931,000
7.	Онцгой байдлын газрын 08 дугаар сараас 11 дүгээр сард гэмшгийн дуудлагаар гарч ажилласан шатахууны зардал	1,649,608
	Дүн	21,652,408

__ооо__